


**Улсын нэгдүгээр төв эмнэлэгийн 2021 оны жилийн эцсийн
статистикийн тайлан
/2021.01.01-11.30 хүртэлх/**

АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Амбулаторийн үзлэг 254239 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 18.8% (n=58,679)-аар буурсан байна.




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад :

Амбулаторит анхан үзлэг 20% (n=40,470), давтан үзлэг 17,3% (n=17,427), урьдчилан сэргийлэх үзлэг 7,1% (n=782)-аар буурсан байна.

АМБУЛАТОРИЙН ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ

Амбулаторийн халдварт бус өвчлөл 114,349 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 9,2% (n=11,587)-аар буурсан байна.




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад :

Шинэ өвчлөл нь 32% (n=19,052)-аар буурсан бол хуучин өвчлөл 11,2% (n=7,465)-аар өссөн байна.

ОСОЛ ГЭМТЭЛ

2021 оны эхний 11 сарын байдлаар осол гэмтлийн шалтгаант 1751 өвчлөл бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,5 дахин (n=1246) нэмэгдсэн байна.

Осол гэмтлийн өвчлөлийг төрлөөр харуулбал:




- ✓ Угаарын хийн хордлого – 743
- ✓ Спиртийн хордлого-343
- ✓ Амиа хорлохыг завдах -185
- ✓ Хүчирхийлэл – 154
- ✓ Эм, биологийн бэлдмэлийн хордлого-96
- ✓ Бусад хордлого-73
- ✓ Амьгүй механик хүчинд өртөх –65
- ✓ Бүх төрлийн уналт –51
- ✓ Амьтай механик хүчинд өртөх –22
- ✓ Зам тээврийн осол –12
- ✓ Бусад - 7

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл нь өмнөх онтой харьцуулахад 2,5 дахин өссөн байгаа нь COVID-19 өвчний улмаас цэргийн төв эмнэлгийн хордлогийн шалтгаант өвчлөлийг УНТЭ авдаг болсон. Мөн 2020.11 сараас СБД-ийн осол гэмтлийн шалтгаант өвчлөлийг авдаг болсонтой холбоотой.

СТАЦИОНАРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2021 оны эхний 11 сарын байдлаар стационарт 15,859 хэвтэн эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлж урьд оны мөн үеийнхээс 22,4% (n=4,588)-аар буурсан байна.

Стацинорит хэвтэн эмчлүүлсэн хүн болон ор хоног:




Нийт ашигласан ор хоног 15,859 бөгөөд дундаж ор хоног 6.5, орны фонд ашиглалт 82,2% байна

2021.04.16-аас эмнэлгийн өргөтгөл /зүүн байр/-ийг Ковид-19 өвчний тусламж үйлчилгээ үзүүлэхээр 152 ор дэлгэсэн. Энэ хугацаанд ковидын тасагт 2,854 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлээд гарсан бол нас барсан 199 тохиолдол байна.

Нийт ашигласан ор хоног 26,376 бөгөөд дундаж ор хоног энгийн тасаг 8,5, эрчимтийн тасаг нь 9,6 байна.

МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ онд нийт 8,723 мэс засал орж өмнөх оноос 29,7% (n=3,681)-аар буурсан байна.



Төлөвлөгөөт мэс засал 35,5% (n=3,130), яаралтай мэс засал 15,3% (n=551), дурангийн мэс засал 32,2% (n=1,260)-аар тус тус буурсан байна.

НАС БАРАЛТ


Энэ оны эхний 11 сард нас баралтын 525 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 12,4% (n=65) нь эмнэлэгт хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Урьд онтой харьцуулвал нас баралт 169 тохиолдлоор, хоног болоогүй нас баралт 22 тохиолдлоор өссөн байна.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт нийт нас баралтын 1,5% (n=8)-ийг эзэлж байгаа бөгөөд 5 тохиолдол нь архины шалтгаант нас баралт байна.

Эхийн эндэгдэлийн 8 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 7 тохиолдол нь Ковид-19 өвчний шалтгаант нас баралт байна.

Нас баралтын бүтцийг авч үзвэл:



Нас баралтын өвчлөлийн бүтцээр авч үзвэл Ковид-19 32,6% (n=171), ХБЭ 14,7% (n=77), хавдар 13% (n=68), АЗЭ 11% (n=58), ЗСЭ 6,7% (n=35), харвалт 5,7% (n=30)-ийг тус тус эзэлж байна.